




2017

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУРААНГУЙ

**“ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ХӨГЖИЛ, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ”**

СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУРААНГУЙ

| 2017 ОНЫ 9-Р САРЫН 27-НЫ ӨДӨР





АГУУЛГА

<i>1-р хэсэг: Монголбанкны ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал судалгааны үр дүнгийн тайлан</i>	4
<i> ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал</i>	4
<i> ЖДҮ-ийн судалгааны үр дүн</i>	5
<i>2-р хэсэг: Хэлэлцүүлэгт оролцогчдын санал</i>	6
<i>3-р хэсэг: Хэлэлцүүлэгт оролцогчдын тавьж буй нийтлэг асуудал</i>	9



Монголбанкны ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал судалгааны үр дүнгийн тайлан

Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал

Монголбанкны Судалгаа статистикийн газраас хийж гүйцэтгэсэн “Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” түүвэр судалгааны үр дүнг 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр олон нийтэд танилцуулж нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Монголбанкнаас Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг дунд үйлдвэрүүдийн өнөөгийн хөгжил, тулгарч байгаа саад бэрхшээл болон санхүүгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор түүвэр судалгааг жил бүр, Улаанбаатар хот болон 21 аймаг дахь бизнес эрхлэгч нарын дунд явуулж байна. Зургаа дахь жилдээ хийж буй уг судалгаанд Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 1970 гаруй жижиг дунд бизнес эрхлэгчид хамрагдсан. Монголбанк нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төв байгууллагуудын нэг төдийгүй судалгаа, шинжилгээний институт юм. Иймд Монголбанк жижиг дунд үйлдвэрлэгчдийн тавьж буй санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, зээлийн нөхцөлийг эрэлт хэрэгцээнд тохируулах, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх талаарх хүсэлт, шаардлагыг төрийн бодлогод тусгуулах гүүр болж ажиллаж байна.

Монголбанк нь Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам болон бусад байгууллагуудтай хамтран санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж УИХ-аар батлуулахаар ажиллаж байна. Иймд энэ хэлэлцүүлэг дээр гарч ирэх санал, санаачлага нь бодлогын баримт бичиг бодит байдалд нийцтэй, үр дүнтэй байхад чухал ач холбогдолтой юм. Та бүхэн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохыг хүсье.



Д.Ган-Очир

**ЖДҮ-ийн
түүвэр
судалгааны үр
дүнг олон
нийтэд
танилцууллаа.**

Монголбанкны ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал судалгааны үр дүнгийн тайлан

“Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” судалгааны үр дүн



С.Билгүүн

ЖДҮ эрхлэхэд санхүүжилтийн бэрхшээл тулгарч байна.

Монголбанкны ССГ-ын судалгааны хэлтсийн ахлах эдийн засагч С.Билгүүн “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” судалгааны үр дүнгээр илтгэл тавилаа. Жижиг дунд үйлдвэрлэлийн түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарсан:

- Бизнесийн идэвхжил муудсанаар эргэлтийн хөрөнгөөр дутагдах, үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлэх, цаашид үйлдвэрлэлээ өргөтгөхөд санхүүжилтийн бэрхшээл тулгарч байна;
- ЖДҮ эрхлэгчдэд Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлөн хүртээмжтэй биш, олдоц бага бөгөөд арилжааны банкуудаас голлон санхүүжилт авдаг байна;
- ЖДҮ эрхлэгчдэд 1-5 жилийн хугацаатай 10-50 сая төгрөг хүртэлх санхүүжилт авах хэрэгцээ байна;
- ЖДҮ эрхлэгчдэд макро эдийн засгийн орчны зүгээс валютын ханш болон инфляци, нийгэм орчны зүгээс ядуурал болон ажилгүйдэл хүндрэл бий болгож байна.

Хэлэлцүүлэгт оролцогчдын санал

Хэлэлцүүлэгт бизнесийн салбарынхан болон судалгааны байгууллагуудын төлөөлөл өргөнөөр оролцож, санал хүсэлтээ илэрхийлсэн юм.

Тус хэлэлцүүлэгт шийдвэр гаргагчдыг төлөөлж УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ оролцож, судалгааны үр дүнг бодлогод тусгах, тулгарч буй бэрхшээл саадыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах тухай өөрийн саналаа илэрхийллээ. Тэрээр судалгааны ажлын ач холбогдлыг үнэлж, талархал илэрхийлсэн.

Цаашид авч хэрэгжүүлэх саналын хүрээнд ЖДҮ-ийн хөгжлийг дэмжихийн ач холбогдлыг онцолж, “Шинэ Хөдөө” хөтөлбөрийг санаачилж буйгаа дуулгаж, хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх арга замын талаар мэдээлэл өгсөн. Мөн тэрээр энэ санал санаачлагын талаар хэлэлцүүлэгт оролцогсдыг санал, бодлоо хэлэхийг хүссэн. Эцэст нь энэ хөтөлбөрийг дэмжиж, Монголбанк болон бусад холбогдох байгууллагуудыг хамтран ажиллахыг уриалав.



**“Шинэ Хөдөө”
хөтөлбөрт
холбогдох
байгууллагууд
идэвхтэй
оролцох
хэрэгтэй.**

Хэлэлцүүлэгт оролцогчдын санал

**Х.Цэвэлмаа****Ж.Сүхбаатар****С.Дэмбэрэл****Г.Бумчимэг****Х.Цэвэлмаа**

*Эдийн засгийн ухааны
профессор*

Монгол Улсын Их сургууль

Ж.Сүхбаатар

*Дэд захирал, эдийн засгийн
салбарын эрхлэгч*

Улаанбаатар Их сургууль

С.Дэмбэрэл

ТУЗ-ийн дарга

Зах зээл судлалын хүрээлэн

Г.Бумчимэг

Гүйцэтгэх захирал

Монголын Эдийн засгийн
шинжилгээ судалгааны төв

Х.Цэвэлмаа судалгааны чанарын хүрээнд асуултуудын хамрах хүрээг сайжруулахын тулд хөдөлмөрийн бүтээмж, үр чадвартай ажилчдын тоо, өртгийн сүлжээ, материалын барьцаа, старт-ап компаниудын талаарх асуултуудыг оруулах, зөвхөн дэмжлэг үзүүлж байгаа байгууллагуудаас гадна ЖДҮ эрхлэгчтэй холбоотой ажилладаг байгууллагуудын талаар асуух нь чухал болохыг онцолсон. Цаашид авах арга хэмжээний хувьд инноваци хийж байгаа компаниудад татварын хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй гэсэн санал дэвшүүлсэн.

Ж.Сүхбаатар судалгааны ажлын чанарын хүрээнд ач холбогдлыг үнэлж, талархал илэрхийлсэн. Цаашид авах арга хэмжээний хувьд үндсэн хуульд ЖДҮ-ийн хөгжлийн талаар хөндөж оруулах, инноваци хийж буй ЖДҮ эрхлэгчдийг дэмжих бодлоготой болох зэрэг саналыг дэвшүүлсэн.

С.Дэмбэрэл судалгааны чанарын хүрээнд судалгааны ач холбогдлыг сайжруулах, хүнд суртлын индекс тооцож, ямар байгууллага хамгийн ихээр хүнд суртал учруулдаг болохыг асуух, бизнесийн оролт, гаралт, цэвэр өсөлт, бизнесээс гарсан шалтгаан зэргийг асуух, зээл авах хэлбэрийг илүү нарийн асуух хэрэгтэй гэсэн санал хэлсэн. Цаашид авах арга хэмжээний хувьд судалгааны үр дүнг бодлогын хэрэгсэл болгох, барьцаа хөрөнгийн үнэлгээний эрх зүйн асуудлыг сайжруулах зэрэг саналыг дэвшүүлсэн.

Г.Бумчимэг судалгааны чанарын хүрээнд яагаад санхүүгийн тайлан гаргадаггүй вэ гэдгийг илүү нарийн асуух, Татварын ерөнхий газраас гаргадаг тоонуудтай түүвэр судалгааны үр дүнгээ харьцуулан харах хэрэгтэй гэсэн саналыг хэлсэн.

Хэлэлцүүлэгт оролцогчдын санал

**Д.Болор-Эрдэнэ****В.Данаасүрэн****С.Сувдаа****С.Бат-Оргил****Д.Өлзийсайхан**

Д.Болор-Эрдэнэ судалгааны чанарын хүрээнд ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ тал уруу нь илүү хандсан асуултуудыг асуух хэрэгтэй хэмээн санал хэлэв. Цаашид авах арга хэмжээний хувьд хөнгөлөлттэй зээлийн шаардлага, нөхцөл зэрэг нь эргээд зах зээл дээр гажуудал үүсгэж буй тул нөхцөл шаардлагыг эргэн харах, ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгцээ өндөр байгаа зэрэг саналыг дэвшүүлсэн.

В.Данаасүрэн цаашид авах арга хэмжээний хувьд Монголбанкны зүгээс зээлийн хүүг бууруулах тал дээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, өрсөлдөх чадвартай, нэмүү өртөг шингэсэн өвөрмөц бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэсэн саналыг дэвшүүлсэн.

С.Сувдаа цаашид авах арга хэмжээний хувьд Монголбанкны зүгээс холбогдох байгууллагуудад судалгааны үр дүнд үндэслэн бодлогын санал, зөвлөмжүүдийг хүргүүлж байх саналыг дэвшүүлсэн.

С.Бат-Оргил арилжааны банкны зүгээс ЖДҮ эрхлэгчдэд зээл олгохдоо барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулдаг боловч Монголбанкны зүгээс явуулж буй шалгалттай холбоотойгоор шаардлагыг нэмэгдүүлэх тохиолдол гардаг. Иймд барьцаа хөрөнгийн үнэлгээг илүү тодорхой болгох, Монголбанкны зүгээс холбогдох байгууллагуудтай хамтран Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг сайжруулах хэрэгтэй зэрэг саналыг дэвшүүлсэн.

Д.Өлзийсайхан судалгааны чанарын хүрээнд санамсаргүй аргаар түүврээ сонгох нь зарим талаар мэдээллийг бүрэн илэрхийлэхэд дутагдалтай байдаг учир цаашид бусад орны жишгийн дагуу ЖДҮ-ийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, түүнд үндэслэн судалгаа хийх, бодлого боловсруулах хэрэгтэй хэмээн үзсэн.

Д.Болор-Эрдэнэ

*Бизнесийн банкны хэлтсийн захирал
Хас банк*

В.Данаасүрэн

*Баруун бүсэд нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагааг дэмжих төслийн Бизнесийн хөгжлийн зөвлөх
Азийн хөгжлийн банк*

С.Сувдаа

*Жижиг дунд үйлдвэр хариуцсан ахлах мэргэжилтэн
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам*

С.Бат-Оргил

*Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал
Тээвэр хөгжлийн банк*

Д.Өлзийсайхан

*Хөгжлийн санхүүжилтийн газрын зээл тусламж бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Сангийн яам*

Хэлэлцүүлэгт оролцогчдоос тавьж буй нийтлэг асуудал



**Судалгааны үр
дүнг бодлогын
баримт бичигт
тусган,
хэрэгжүүлэх
нь чухал
байна.**

Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн талаарх судалгаануудад нийтлэг тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар тодорхой гаргадаг ч бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг хэлэлцүүлэгт оролцогчид онцолж байв.

Тиймээс үүсч буй бэрхшээл, шийдвэрлэвэл зохих арга хэлбэрүүдийг судалгааны түвшинд дүгнэлт гаргаад орхих бус бодлогын баримт бичигт тусгаж, шийдвэрлүүлэх нь тулгамдаж буй гол асуудал болж байгааг хөндөв.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУРААНГУЙ

| 2017 ОНЫ 9-Р САРЫН 27-НЫ ӨДӨР

